

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/27/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/228
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн 312,900.0 мянган төгрөгийн хөрөнгөөр гэр хорооллын айл өрхүүдийг 04 шугамд холбох ажил, хогийг цэгийг хашаажуулах, гэрэлтүүлэг, камержуулах, гэр хороолол, нийтийн орон сууц үйлчилгээний газруудыг төвлөрсөн халаалтын шугамд холбох, халаалтын шугамын өргөтгөл зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 47 зорилт 153 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 81,53%-тай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Тайлант онд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 3,079,037.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 198,270.2 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

G/Arkhir/Alban bichig 2023/A4
19020297

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,389,640.2	838,815.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	780,818.3	306,209.7
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	307,550.6	422,854.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	301,271.3	109,751.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,542,957.4	1,801,792.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,542,957.4	1,801,792.0
39200	Биет хөрөнгө		4,387,059.4	1,714,805.2
39300	Биет бус хөрөнгө	13	155,898.0	86,986.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		5,932,597.6	2,640,607.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		15,846.6	78,841.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	15,846.6	78,841.5
41300	Өглөг	17а, 17б	15,846.6	78,841.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,916,751.0	2,561,766.3
51	Засгийн газрын хувь оролцоо		5,916,751.0	2,561,766.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,798,965.5	855,319.2
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		2,798,965.5	855,319.2
51200	Хуримтлагдсан үр дүн		2,325,522.1	1,294,554.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		792,263.4	411,892.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		5,932,597.6	2,640,607.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,555,180.8	1,063,329.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		204,978.8	335,277.9
110	Орлогын албан татвар		55,354.8	148,287.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		55,354.8	157,015.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-8,728.4
113	Хөрөнгийн албан татвар		46,910.8	45,018.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж		102,713.1	141,971.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	739,766.5	71,652.5
120	Нийтлэг татварын бус орлого		739,766.5	71,652.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,610,435.6	656,398.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,870,326.2	1,093,570.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,870,326.2	836,632.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,984,241.4	834,681.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,074,045.3	279,107.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		134,358.8	33,338.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		231,319.5	244,688.4
2104	Хангамж, бараа материалын зардал		66,552.9	36,086.9
2105	Нормативт зардал		173,701.7	33,634.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,435.0	7,467.4
2107	Томилолт, зочны зардал		2,664.5	3,607.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,371.4	4,835.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		288,792.3	191,916.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		886,084.8	1,951.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	256,938.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		684,854.6	-30,241.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		63,778.0	3,320,057.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		621,076.7	-3,350,298.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

		/ мянган төгрөгөөр/		
Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,295,674.3	0.0	5,295,674.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,847.5	0.0	2,847.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,298,521.8	0.0	5,298,521.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,847.5	0.0	-2,847.5
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	621,076.7	0.0	621,076.7
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,916,751.0	0.0	5,916,751.0
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,916,751.0	0.0	5,916,751.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,686.0	0.0	-4,686.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,912,065.0	0.0	5,912,065.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-3,350,298.7	0.0	-3,350,298.7
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,561,766.3	0.0	2,561,766.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,319,294.8	1,096,475.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	204,978.8	335,277.9
110	Орлогын албан татвар	55,354.8	148,287.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	55,354.8	157,015.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-8,728.4
113	Хөрөнгийн албан татвар	46,910.8	45,018.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	102,713.1	141,971.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	25,913.2	31,062.6
1181	Газрын төлбөр	2,927.8	5,599.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	73,872.1	105,309.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	503,880.4	104,798.1
120	Нийтлэг татварын бус орлого	503,880.4	104,798.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,610,435.6	656,398.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,578,704.2	692,856.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,578,704.2	692,856.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,690,827.0	670,904.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,031,423.4	261,577.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,950.3	33,799.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,712.3	245,183.4
2104	Хангамж, бараа материалын зардал	45,685.8	32,327.0
2105	Нормативт зардал	84,466.5	29,602.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,527.0	9,850.0
2107	Томилолт, зочны зардал	2,664.5	3,307.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,034.2	20,199.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	152,362.9	35,059.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	887,877.3	21,951.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	740,590.5	403,618.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	73,614.8	878,127.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	73,614.8	878,127.3
2200	Дотоод эх үүсвэрээр	73,614.8	878,127.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-73,614.8	-878,127.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-40,768.0	-100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,768.0	100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	626,207.7	-474,608.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	154,610.6	780,818.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	780,818.3	306,209.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,742,996.40	1,513,174.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	678,570.40	634,947.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	676,570.40	632,948.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,805.80	261,577.57
210101	Үндсэн цалин	225,306.90	209,560.49
210102	Нэмэгдэл	47,993.70	42,904.05
210104	Урамшуулал	8,505.20	8,883.21
210105	Гэрээт ажлын хөлс	-	229.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,587.70	33,799.05
210201	Тэтгэврийн даатгал	26,315.00	23,549.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,818.30	2,686.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,254.50	2,058.40
210204	Ажилгүйдлийн даатгал	563.90	497.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5,636.00	5,007.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	258,452.90	245,183.35
210301	Гэрэл, цахилгаан	20,977.00	20,042.38
210302	Түлш, халаалт	236,599.90	224,881.97
210303	Цэвэр, бохир ус	876.00	259.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,067.90	30,037.20
210401	Бичиг хэрэг	1,176.70	1,668.00
210402	Тээвэр, шатахуун	23,009.60	22,685.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,781.60	1,924.00
210404	Ном, хэвлэл	900.00	560.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200.00	3,200.00
2105	Нормативт зардал	600.00	600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600.00	600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,850.00	9,850.00
210604	Урсгал засвар	9,850.00	9,850.00
2107	Томилолт, зочны зардал	3,150.20	3,081.00
210702	Дотоод албан томилолт	3,150.20	3,081.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,221.90	19,533.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,746.70	18,076.79
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	712.80	712.80
210803	Даатгалын үйлчилгээ	288.40	288.40
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320.00	316.17
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154.00	139.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,834.00	29,286.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,334.00	26,786.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500.00	2,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000.00	1,999.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000.00	1,999.26
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000.00	1,999.26
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	944,426.00	878,127.32
220001	Барилга байгууламж	456,419.90	412,779.96
221001	Их засвар	55,000.00	55,000.00
222001	Тоног төхөөрөмж	216,052.00	230,372.70
223001	Бусад хөрөнгө	216,954.10	179,974.66
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000.00	100.00
230001	Эргэж төлөгдөх зээл	120,000.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,742,996.40	1,458,304.96
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	244,304.80	244,304.80
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	244,304.80	244,304.80
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	728,570.40	1,171,146.02
320001	Орон нутгийн төсвөөс	728,570.40	1,171,146.02
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	770,121.20	42,854.13
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000.00	42,804.13
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	50.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	650,121.20	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	157,450.69
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	82,628.38
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	40	46
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5
610001	Төсвийн байгууллага	5	5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	93	87
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	20	17
620003	Үйлчлэх ажилтан	61	58
620004	Гэрээт ажилтан	4	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	23
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	6
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18	11
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	166196.3	14940.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	166196.3	14940.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	107216.8	7107.4
2104	Хангамж, бараа материалын зардал	300.0	1032.8
210402	Тээвэр, шатахуун	300.0	1032.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	869.6	302.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	869.6	302.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106047.2	5772.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101643.2	5772.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4404.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58979.5	7833.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	54263.9	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33612.6	0.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19643.3	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1008.0	0.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4715.6	7833.2
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	4645.2	7833.2
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	70.3	0.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	166196.3	14940.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	166196.3	14940.6
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2208.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	161022.1	11071.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2966.1	3869.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга нийтийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай, хариуцлагатай хүргэж шууд ардчиллын зарчмыг баримталсан мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны тунгалаг байгууллага болох зорилт тавин ажилласан байна.

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн 312,900.0 мянган төгрөгийн хөрөнгөөр гэр хорооллын айл өрхүүдийг 04 шугамд холбох ажил, хогийг цэгийг хашаажуулах, гэрэлтүүлэг, камержуулах, гэр хороолол, нийтийн орон сууц үйлчилгээний газруудыг төвлөрсөн халаалтын шугамд холбох, халаалтын шугамын өргөтгөл зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 47 зорилт 153 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 81,53%-тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29, 2022 оны 7 дугаар сарын 01, 2022 оны 8 дугаар сарын 29, 2022 оны 12 дугаар сарын 09-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/02 тушаалаар томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын дотоод хяналт шалгалтын багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, сумын Засаг дарга хяналт шалгалтын зорилго, чиглэл, багийн бүрэлдэхүүнийг томилсон байна. Төв аймгийн Баян-Өнжүүл сумын дотоод хяналт шалгалтын баг

тайлант онд 7 зүйл 15 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулан төлөвлөгөөний дагуу улирал бүр хяналт шалгалтыг хийн илтгэх хуудас бичиж, зөвлөмж өгч ажилласан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,291,989.8 мянган төгрөгөөр буюу 44,5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	780,818.3	306,209.7	-474,608.6
Авлага	307,550.6	422,854.4	115,303.8
Бараа материал	301,271.3	109,751.8	-191,519.5
Үндсэн хөрөнгө	5,932,597.6	2,640,607.8	-3,291,989.8
Нийт хөрөнгө	6,945,064.5	4,867,937.7	-2,077,126.8
Өр төлбөр	15,846.6	78,841.5	62,994.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,916,751.0	2,561,766.3	-3,354,984.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,932,597.6	2,640,607.8	-3,291,989.8

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 474,608.6 мянган төгрөгөөр буурч 306,209.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь тайлант онд орон нутгийн орлого 203,570.4 мянган төгрөг нь орон нутгийн орлогын үлдэгдэл, орон нутгийн хөгжлийн сан 30,014.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын хийгдээгүй ажлын үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сангийн 52,614.1 мянган төгрөгийн үлдэгдэл, байгаль хамгаалах сангийн 9,516.9 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл, 10,494.0 мянган төгрөгийн эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 422,854.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 115,303.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн хөгжлийн сан 149,400.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 4,272.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, Хоршоо хөгжүүлэх сан 37,947.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төв 400.0 мянган төгрөгөөр, Соёлын төв 22.0 мянган төгрөгөөр бууруулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 109,751.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 191,519.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 198,270.2 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,640,607.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,291,989.8 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль,

Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 3,079,037.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 78,841.5 мянган төгрөг болж 62,994.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Засаг даргын тамгын газрын шилжих үлдэгдлээр хийсэн хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл 78,841.5 мянган төгрөгийн өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,561,766.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,354,984.7 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 3,350,298.7 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 306,209.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 474,608.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	780,818.3	306,209.7	-474,608.6
Төгрөг	780,818.3	306,209.7	-474,608.6
Төрийн сангийн харилцах	775,932.3	295,715.6	-480,216.7
Арилжааны банк дахь харилцах	4,885.9	10,494.0	5,608.1
Дүн	780,818.3	306,209.7	-474,608.6

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн хөрөнгийн тодруулга тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 306,209.7 мянган төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 295,715.6 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 10,494.0 мянган төгрөг байршиж байна. Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 306,209.7 мянган төгрөгийн 66,5 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын 203,570.4 мянган төгрөг, 9,8 хувь буюу Орон нутгийн хөгжлийн сангийн 30,014.2 мянган төгрөг, 17,1 хувь буюу Хоршоо хөгжүүлэх сангийн 52,614.1 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 3,4 хувь буюу 10,494.0 мянган төгрөг, байгаль хамгаалах сангийн 3,2 хувь буюу 9,516.9 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл нь 474,608.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос орон нутгийн төсвийн орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 405,439.3 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 97,529.1 мянган төгрөгөөр гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Цэцэрлэг 45.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн төв 19,952.3 мянган төгрөгөөр буурч, Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 42,704.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 5,653.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт

1.Баян-Өнжүүл сумын Орон нутгийн хөгжлийн сан экскаватор худалдан авсан мөнгийг олгохдоо ХХОАТ суутгаж 7,400.0 мянган төгрөг олгосон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчсөн зөрчилд зөвлөмж өгсөн.

2.Баян-Өнжүүл сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны 04 дүгээр тогтоолоор сумын 2022 оны төсөвт тодотгол хийгдэж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд өөрчлөлт оруулсан байна. Гэтэл Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн ойн зурвасын хашааны ажлын төсвийг 34.0 сая болгосон байхад 35.0 саяар, ЕБС-ийн дотуур байрны 1 тасаг тохижуулах, цэцэрлэгийн багш хөгжлийн танхим ажлын төсвийг 5.0 сая болгосон байхад 6.0 саяар гэрээ хийж гүйцэтгүүлсэн. Мөн Эрүүл мэндийн төвийн амралтын өрөө тохижуулах ажил хасагдсан байхад 7.0 сая төгрөгөөр гэрээ хийж гүйцэтгүүлсэн нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн зөрчилд албан шаардлага өгсөн.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 422,854.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 115,303.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	16,687.9	14,472.0	-2,215.9
Байгууллагаас авах авлага	24,422.0	173,400.0	148,978.0
Хувь хүмүүсээс авах авлага	266,440.7	234,982.4	-31,458.3
Дүн	307,550.6	422,854.4	115,303.8

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн авлагын тодруулга тайлан

Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн 244,662.4 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 57,8 хувийг, байгууллагаас авах орон нутгийн хөгжлийн сангаар хийж гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын дутуу ажлын авлага 173,400.0 мянган төгрөг буюу 41,0 хувийг, Эмийн эргэлтийн сангийн авлага 4,792.0 мянган төгрөг буюу 1,2 хувийг эзэлж байна. Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 422,854.4 мянган төгрөгийн 55,6 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 41,0 хувийг байгууллагаас авах авлага, 3,4 хувийг зээлийн хүүгийн авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 109,751.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 191,519.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	91,485.4	10,658.6	-80,826.8
Тусгай зориулалттай материал	57,807.0		-57,807.0
Эм боох материал	33,678.4	10,658.6	-23,019.8
Хангамжийн материал	194,635.8	90,243.3	-104,392.5
Бичиг хэргийн материал	9,735.7	2,887.4	-6,848.3
Аж ахуйн материал	111,027.2	41,125.0	-69,902.2
Сэлбэг хэрэгсэл	2,404.8		-2,404.8
Хүнсний материал	14,963.7		-14,963.7
Бусад хангамжийн материал	56,504.4	46,230.9	-10,273.5
Мал амьтад	15,150.0	8,850.0	-6,300.0
Дүн	301,271.2	109,751.9	-191,519.3

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн бараа материалын тодруулга тайлан

Бараа материалын үлдэгдэл 109,751.9 мянган төгрөгийн 88,5 хувь буюу 97,142.4 мянган төгрөгийг Засаг даргын тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1,950.8 мянган төгрөг буюу 1,2 хувийг, Эмийн эргэлтийн сангийн 10,658.6 мянган төгрөг буюу 9,7 хувийг эзэлж байна. Бараа материал данс худалдан авсан 93,748.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй 38,997.6 мянган төгрөг нийт 132,746.5 мянган төгрөгөөр нэмэгдэж бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 198,270.2 мянган төгрөг, акталсан 41,649.0 мянган төгрөг, зарцуулсан 84,346.9 мянган төгрөг нийт 324,266.1 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,801,792.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,741,165.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,387,059.4	1,714,805.2	-2,672,254.2
Барилга, байгууламж, орон сууц	3,861,092.2	1,240,841.2	-2,620,251.0

Авто-тээврийн хэрэгсэл	120,902.6	155,060.4	34,157.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	162,191.2	72,483.5	-89,707.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	32,823.1	5,820.2	-27,002.8
Бусад үндсэн хөрөнгө	195,456.2	240,599.8	45,143.6
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	452.5	-	-452.5
Номын фонд	14,141.6	-	-14,141.6
Биет бус хөрөнгө	155,898.0	86,986.8	-68,911.2
Программ хангамж	1,298.0	870.8	-427.2
Бусад биет бус хөрөнгө	154,600.0	86,116.0	-68,484.0
Дүн	4,542,957.4	1,801,792.0	-2,741,165.5

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үндсэн хөрөнгийн тодруулга тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,1 хувь буюу 1,785,775.4 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 116.6 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө, 0,9 хувь буюу 334.0 мянган төгрөгийн хөрөнгийг Хоршоо хөгжүүлэх сан эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 1,801,792.0 мянган төгрөг болж, худалдан авсан 359,469.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан 138,000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, акталж устгасан 10,941.6 мянган төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 3,079,037.9 мянган төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулийн 1,261,229.4 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 868,752.5 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 365,249.5 мянган төгрөгийн, Соёлын төвийн 583,806.5 мянган төгрөгийн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 78,841.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 71,599.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	7,196.6	78,841.5	71,644.9
Хувь хүмүүст төлөх өглөг	45.0	0	-45.0
Дүн	7,241.6	78,841.5	71,599.9

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн өглөгийн тодруулга тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Засаг даргын тамгын газрын 78,841.5 мянган төгрөгийн өглөг байна. Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 78,841.5 мянган төгрөг болж, 71,599.9 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн нь Засаг даргын тамгын газрын конторын барилгын өргөтгөлийн санхүүжилт дутуугаас үүссэн 78,841.5 мянган төгрөгийн өглөгөөр өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,561,766.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,354,984.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,798,965.5	855,319.2	-1,943,646.3
Хуримтлагдсан үр дүн	2,325,522.1	1,294,554.9	-1,030,967.2
Өмнөх үеийн үр дүн	1,704,445.4	4,644,853.5	2,940,408.1
Тайлант үеийн үр дүн	621,076.7	-3,350,298.7	-3,971,375.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	792,263.4	411,892.2	-380,371.2
Дүн	5,916,751.0	2,561,766.3	-3,354,984.7

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,561,766.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,354,984.7 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр Засгийн газрын сан 1,943,646.3 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 380,371.2 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 2,940,408.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 3,971,375.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,365,855.5 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 278,727.6 мянган төгрөг, 2022 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,644,583.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 4 дүгээр тогтоолд зааснаар Баян-Өнжүүл сумын Засаг дарга тайлант онд 278,727.6 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 501,607.4 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 244,304.8 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 169,943.3 мянган төгрөгөөр, сумын шилжих үлдэгдлийг 450,000.0 мянган төгрөгөөр нийт 1,644,583.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 5 дугаар тогтоолд зааснаар Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 120,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 4 дүгээр тогтоолд зааснаар Баян-Өнжүүл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 48,044.0 мянган төгрөгөөр орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлж 326,771.6 мянган төгрөг төвлөрүүлэхээр, гүйцэтгэлээр 360,669.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 110,4 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлого 5,986.7 мянган төгрөгөөр урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, үл хөдлөх хөрөнгийн татвар 3,478.4 мянган төгрөгөөр, бууны албан татвар 130.0 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 4,400.5 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 249.5 мянган төгрөгөөр, бусад орлого 71,655.8 мянган төгрөгөөр, түрээсийн орлого 222.7 мянган төгрөгөөр нийт 86,123.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 21,586.7 мянган төгрөгөөр бууруулан 1,622,996.4 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 326,771.1 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 401,798.8 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 244,304.8 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 530,177.9 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 119,943.3 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,458,305.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 87,602.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,513,174.9 мянган төгрөг буюу 86,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 229,821.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь шалтгаалсан байна. Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн зардал 119,900.0 мянган төгрөгөөр хэмнэсэн нь шаардлага хангасан төсөл хөтөлбөр ирүүлээгүйгээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын 2 төсөл, 13 арга хэмжээнд 944,426.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 878,127.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл ажиллагааны зардал	59,859.5	53,232.4	6,627.1	88.9
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	863,791.9	800,261.5	63,530.4	92.6
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	156,311.6	155,880.4	431.2	99.7
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	41,184.9	35,203.5	5,981.4	85.5
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	53,904.4	53,063.9	840.5	98.4
6	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	33,696.0	23,599.4	10,096.6	70.0
8	Хоршоо хөгжүүлэх сан- үндсэн үйл ажиллагааны зардал	120,000.0	100.0	119,900.0	0.1
9	Орон нутгийн хөгжлийн сан-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	414,248.1	391,833.9	22,414.2	94.6
Дүн		1,742,996.4	1,513,174.9	229,821.5	86.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 11,071.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,869.4 мянган төгрөг нийт 14,940.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 14,940.5 мянган төгрөг зарцуулж, 32,308.2 мянган төгрөг буюу Засаг даргын тамгын газар 14,540.5 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 400.0 мянга төгрөг зарцуулж 7,833.2 орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдааныг Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу улирал бүр хуралдах	Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдааныг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу улирал бүр 71,85%-н ирцтэйгээр хуралдсан.	59,859.5	53,232.4
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 8 зорилт, хэрэгжүүлэх 46 арга хэмжээ хэрэгжүүлэх	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, хэрэгжүүлэх 46 арга хэмжээ 86,1 %-тай дүгнэгдсэн байна.	863,791.9	800,261.5
3	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн сан 120,000.0 мянган төгрөг баталсан.	Үүнээс зээлийн шаардлага хангах хоршоо байгаагүй учир зээл олгогдоогүй байна. хэрэгжилт 0	120,000.0	100.0
4	71802- Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	-Хөгжсөн багшаас чадварлаг сурагч, Хүүхдэд ээлтэй дотуур байр, Хүүхдийн хүмүүжил төлөвшил, “Оюунлаг Төв аймаг” гэсэн 4-н дэд хөтөлбөр	хэрэгжилт 100%	156,311.6	155,880.4

5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Сургалтын орчныг стандартад нийцүүлэн хөгжүүлж, хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээг тусгасан сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэн, сургуулийн өмнөх насны хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэн, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.	зуны сургалтыг зохион байгуулан, цэцэрлэгт хамрагдаж чадаагүй, хөдөөгийн малчдын 2-5 насны 25 хүүхдийг хамруулан сургасан, гэрээр ажиллах дасгал даалгаврыг 58 хүүхдэд боловсруулан хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь-88.9%	41,184.9	35,203.5
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Нийт 4 төлөвлөгөө 11 зорилт дэвшүүлсэн	хэрэгжилт 85,5%	53,904.4	53,063.9
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээг бий болгож, зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамралтыг нэмэгдүүлнэ.	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг нийт 310 хүн, 4 төрлийн эрт илрүүлэг үзлэгт 2778 хүн хамрагдахаас 1430 хүн хамралт 51,5%, 0-17 насны урьдчилан сэргийлэх үзлэг 785 хүүхэд хамрагдахаас 394 - 50.1 %	33,696.0	23,599.4
9	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Төрийн албан хаагчдын 4 айлын орон сууц барих, ковш авах, 04 шугамын өргөтгөл, Ойн зурвасын хашаа, Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, Хогийн цэгийн хашаа, Мал угаалгын ванн барих, ЕБС-ийн багш хөгжлийн танхимын тохижуулах, Сургуулийн өмнөх боловсролын багш хөгжлийн танхимын тохижуулах, Гудамж талбайн хаягжуулалт, ЭМТ-ийн амралтын өрөө тохижуулах, ЕБС-н дотуур байрны жишиг тасаг тохижуулах гэсэн 12 арга хэмжээ дэвшүүлсэн.	10 арга хэмжээ 100% хэрэгжиж дууссан.4 айлын орон сууц баригдах ажил 60%--тай, Мал угаалгын ванн барих ажил 40%	414,248.1	391,833.9

Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн хөтөлбөр арга хэмжээ хэрэгжээгүй нь шаардлага хангасан төсөл хөтөлбөр иргэн, хоршооноос ирүүлээгүйгээс шалтгаалжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн данстай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 01/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны 1,622,996.4 мянган төгрөгийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаас 1,0 хувиар буюу 16,230.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,361.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн жилд цалин хөлс, НДШ-ийн зардал 24,016.8 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 13,269.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 30.7 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 69.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 2,688.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 3,547.5 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 3.5 мянган төгрөг, хөрөнгийн зардал 66,298.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 38,5 хувь, 5,0 саяас дээших орлогын 12 гүйлгээ, зарлагын 12 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 6 шийдвэр, тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 12 мэдээлэл байршуулахаас 1,262,675.0 мянган төгрөгийн 21 гүйлгээ байршуулаагүй, 72,870.4 мянган төгрөгийн 4 гүйлгээ хугацаа хоцроосон байна.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг 100% хэрэгжүүлж ажилласан байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар НДШ-ийн илүү төлөлтийг барагдуулахтай холбоотой 1 төлбөрийн акт, худалдсан хөрөнгийн орлого төвлөрүүлээгүйтэй холбоотой 1 албан шаардлага, дотоод хяналт, орон нутгийн орлогын бүрдүүлэлт, шилэн данс, цахим худалдан авалттай холбоотой 5 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны 11 дугаар сарын 16-ны өдрийн 01/248 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	248.9	1	248.9	100
Албан шаардлага	1	131,150.0	1	131,150.0	100
Зөвлөмж	5		5		100
Нийт дүн	7	131,398.9	7	131,398.9	100

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,169,716.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,169,716.1 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

1. Тус байгууллага тайлант онд санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үнэ төлбөргүй гарсан үндсэн хөрөнгийн зардал үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнгээс 3,006,007.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Тус байгууллага тайлант онд санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд үнэ төлбөргүй гарсан бараа материалын зардал бараа материалын тодруулга тайлангийн дүнгээс 163,708.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 1,429,502.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 7,833.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,335,545.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 86,123.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1.Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд зарцуулаагүй үлдэгдэл 7,833.2 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Тус байгууллага тайлант онд шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 38.5 хувь, 5,0 саяас дээших орлогын 12 гүйлгээ, зарлагын 12 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 6 шийдвэр, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 12 мэдээлэл байршуулахаас 1,262,675.0 мянган төгрөгийн 21 гүйлгээ байршуулаагүй, 72,870.4 мянган төгрөгийн 4 гүйлгээ хугацаа хоцроосон зөрчил илэрлээ. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд орон нутагт төвлөрүүлэх 7 нэр төрлийн орлогыг 86,123.6 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:Орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
НИЙТ		5	1	4		1			

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	3,169,716.1			2	3,169,716.1	2	3,169,716.1		
ЗДТГ	2	310,844.4	2	310,844.4			2	310,844.4		
Дүн	5	3,480,560.5	2	310,844.4	2	3,169,716.1	5	3,480,560.5		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	93,956.8	1	7,833.2			1	86,123.6
ЗДТГ	2	28,903.4					2	28,903.4
Орон нутгийн хөгжлийн сан	2	17,400.0			1	10,000.0	1	7,400.0
Дүн	6	140,260.2	1	7,833.2	1	10,000.0	4	122,427.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	1,335,545.4			1	1,335,545.4		
ЗДТГ	1	381,561.4					1	381,561.4
Орон нутгийн хөгжлийн сан	1	769,788.4			1	769,788.4		
Дүн	3	2,486,895.2	0	0	1	2,105,333.8	1	381,561.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	3	2,486,895.2	0	0	1	2,105,333.8	1	381,561.4

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn